

**“МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ”,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ, УЛСЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАСГИЙН  
ГАЗРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХОЁРДУГААР ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЛААРХ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 7 дугаар  
сарын 01-ний өдөр

Улаанбаатар  
хот

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлангийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж төслийг хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Уг төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүдээс хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд “Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлангийн хоёрдахь хэлэлцүүлгийг хийх нь зүйтэй гэж үзлээ.

“Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлангийн хоёрдугаар хэлэлцүүлгийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэв.

Анхаарал тавьсанд баярлалаа.

